

“АВЛИГАГҮЙ НИЙГЭМ-ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ГАРЦ”
СЭДЭВТ ҮНДЭСНИЙ БАГА ХУРАЛ ДЭЭР
УИХ-ЫН ДЭД ДАРГА ЛҮНДЭЭЖАНЦАНГИЙН ХЭЛСЭН ҮГ

Монгол Улсын Ерөнхийлөгч өө,
Хатагтай, ноёд оо,

Авлига нь улс орнуудын хөгжил дэвшилд саад тотгор учруулж, ардчилсан шинэчлэлийн явцыг сааруулах, үндэсний эдийн засаг, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн үр ашгийг бууруулах хүчин зүйл болж байгааг дэлхий нийтэд хүлээн зөвшөөрч, дэлхийд нэр хүнд бүхий олон улсын байгууллага, улстөрчид түүний эсрэг тэмцэлд идэвхтэй оролцож байна.

Авлига нь дэлхийн аль ч улс оронд ямар нэгэн хэмжээгээр байгаа бөгөөд тухайн улсын нийгэм, улс төрийн тогтолцоо, засаглалын арга барил, олон нийтийн сэтгэл зүйгээс шалтгаалан янз бүрийн байдлаар оршдог байна.

Авлигын эсрэг тэмцэх, түүнийг бууруулах ажлыг тууштай зохион байгуулж амжилтад хүргэхэд иргэний нийгэм, иргэдийн оролцоо, тэдний дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай байгаа, төр, засаг, иргэний нийгмийн хүч боломжийг нэгтгэн авлигын эсрэг тэмцэхэд чиглэсэн урт хугацааны бодлого хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Их Хурал 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр” баталж, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих Үндэсний зөвлөлийг УИХ-ын дэд даргаар ахлуулан хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх, эрх мэдлийн болон иргэний нийгэм, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан 21 гишүүнтэйгээр байгуулж ажиллуулсан. Энэхүү хөтөлбөр авлигатай тэмцэхэд бүх нийтийн хүч, анхаарлыг нэгтгэн чиглүүлэх зорилготой төрийн бодлогыг тодорхойлсон баримт бичиг болсон юм. Авлигаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, төрийн албыг боловсронгуй болгох, шүүх эрх мэдлийн байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангах, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудаас авах арга хэмжээ, хүнд суртлыг багасгах, эдийн засгийг либеральчлах, авлигатай тэмцэхэд иргэний нийгмийн оролцоог дээшлүүлэх зэрэг чиглэлээр хийж гүйцэтгэх ажлууд, хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, үр дүн зэргийг тодорхой тусгасан юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 193 дугаар зарлигаар Үндэсний зөвлөлийн ажиллах журмыг баталж, журамд заасны дагуу Зөвлөл үйл ажиллагааныхаа дэгийг батлан ажиллаж ирсэн.

2004 оноос НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлсэн “Нийгмийн шударга ёсны тогтолцоог сайжруулах нь” төсөлд Үндэсний зөвлөлийн дарга гарын үсэг зурснаар уг төслийн хүрээнд авлигатай тэмцэх чиглэлээр тодорхой зорилтуудыг тавьж, авлигын эсрэг эрх зүйн орчныг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, Авлигатай тэмцэх Үндэсний зөвлөлийн болон авлигатай тэмцэх байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх, хяналт шалгалтыг сайжруулах, гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх талаарх ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлсэн юм. Одоо энэ төслийг Авлигатай тэмцэх газарт бид шилжүүлсэн байгаа.

Авлигын эсрэг тэмцэлд иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн үүрэг, хууль тогтоогчдын үүрэг оролцоо, хувийн хэвшлийн үүрэг, авлигын эсрэг тэмцэлд гүйцэтгэх засаглал, шүүх, эрх мэдлийн гүйцэтгэх үүрэг зэрэг сэдвүүдээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгэм, нутгийн захиргааны байгууллагуудын төлөөлөл, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг хандивлагчдыг хамруулсан хүрээнд нэгдсэн болон салбар хуралдаануудыг зохион байгуулж, авлигатай тэмцэх талаар зохиож буй ажил, тохиолдож буй бэрхшээл, шийдвэрлэвэл зохих асуудлын талаар санал бодол, туршлагаа харилцан илэн далангүй ярилцаж, авлигатай тэмцэх стратеги бодлого

боловсруулж хэрэгжүүлэхэд тэдгээрийн гүйцэтгэх үүргийг нарийвчлан тодорхойлж, Мянганы хөгжлийн зорилтод 2015 он гэхэд Монгол Улс Авлигыг үл тэвчих бүс нутаг болно гэж заасан.

Төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа хуульд нийцүүлэн төрийн албан хаагч авлигад өртөх боломжийг аль болох хаах явдал юм. Үүний тулд төрийн албан хаагчдад тавих нийтлэг болон тусгай шаардлага, хориглох зүйлсийг Төрийн албаны тухай хууль болон Авлигын эсрэг хуулиар тогтоосон. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Шүүхийн тухай, Прокурорын байгууллагын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Хуульчдыг сонгон шалгаруулах тухай, Татварын багц хууль, Ашигт малтмалын хууль, Олон нийтийн радио, телевизийн хууль, Улс төрийн намуудын тухай хууль, Сонгуулийн тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийг шинэчлэн баталснаар авлигатай тэмцэх эрх зүйн орчинг улам боловсронгуй болгоход томоохон алхам болсон. Дээрх хуулиудыг боловсруулж батлуулахад Авлигатай тэмцэх Үндэсний зөвлөл санаачилгатай ажилласан болно.

Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор бүх яам, агентлагт төрийн нарийн бичгийн дарга, дэд даргаар ахлуулсан авлига, хээл хахуультай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан орон тооны бус салбар зөвлөл ажилласан бөгөөд орон нутагт аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн даргаар ахлуулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл тус тус ажиллав.

Салбар зөвлөлүүдийн хэмжээнд Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр болон Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж хяналт тавих Үндэсний зөвлөлийн жил, улирлын ажлын төлөвлөгөөтэй үйл ажиллагаагаа уялдуулан, салбарын хэмжээнд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөгөө батлан хэрэгжүүлж, үр дүнг нь Үндэсний зөвлөлийн ажлын албанд тогтмол ирүүлж тайлагнаж байв.

“Авлигын эсрэг олон нийтийн санаа бодол, байр суурь” сэдэвт социологийн судалгааг 1999, 2002 онд хийж, салбар зөвлөлүүдийн хүрээнд “Нийгмийн байгууллагууд дахь авлигын түвшин, түүний өөрчлөлт”, “Авлигын талаархи Таны бодол”, “Авлигын гэмт хэрэг, зөрчлийн талаар”, “Авлилга-олон нийтийн санал бодол” зэрэг судалгаануудыг явуулав.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Нийгмийн шударга ёсны тогтолцоог сайжруулах” төслийн хүрээнд Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон нийтийг өргөнөөр хамруулах бүтцийг бий болгох ажлыг Үндэсний зөвлөл ажлын төлөвлөгөөндөө тусган “Авлигын мөн чанар, түүний Монгол оронд үзүүлж буй сөрөг үр дагаврын талаархи ойлголтыг сайжруулахад чиглэгдсэн санаачилга гаргасан төрийн бус байгууллагыг дэмжих үүднээс Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэлтэй төрийн бус байгууллагуудын дунд “Авлигын эсрэг” төсөл уралдааныг зохион явуулав.

Уралдаанд нийт 18 төрийн бус байгууллага төсөл ирүүлснээс хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж болох, цаг үеийн шаардлагыг хангасан, оюуны бүтээл маягаар үлдэх төслүүдийг ажлын хэсэг тусгай журмын дагуу шалгаруулж, 6 төслийг хэрэгжүүлсэн юм.

Төрийн байгууллагуудын хэмжээнд хүнд суртал, шат дамжлагыг цөөлөх талаар тодорхой ажлуудыг хийж, ялангуяа иргэдэд үзүүлэх үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай болгох, тэднийг чирэгдүүлэхгүй байх, тэднээс тавьсан асуудлыг түргэн шуурхай, шат дамжлагагүйгээр шийдвэрлэх тал дээр анхаарч, аливаа үйлчилгээнд хэрэглэх маягт, иргэдийг хүлээн авах цагийн хуваарийг үйлчлүүлэгч болон олон нийтэд ил тод байлгах, мөрдөгдөж буй дүрэм, зааврыг тус тусын байгууллагын вэйб сайтад байрлуулах, иргэдийн санал хүсэлтийг хүлээж авах тусгай өрөө, утас, хайрцаг зэргийг ажиллуулдаг болсон нь сайшаалтай байна.

Салбар зөвлөлүүд, авлига гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд зорилтуудаа оновчтой тодорхойлох, төрийн албан хаагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргуулан авч хэвшүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан хэрэгжүүлэх, авлигын талаархи аливаа мэдээлэл, гомдол, саналыг тухай бүрт нь холбогдох байгууллагуудаар шалгуулах, хариуг мэдээлэх, авлигад өртөж болзошгүй албан тушаалын судалгааг гарган дүгнэлт хийж, авлигын талаар судалгаа явуулах, сургалт, сурталчилгааны гарын авлага, материал бэлтгэх ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Авлигатай тэмцэх салбар зөвлөлүүд улс орнуудын авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын арга туршлагыг судалж, хууль хяналтын болон тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын ажилд нэвтрүүлэх, дээрх чиглэлээр ажиллагсдыг гадаадад сургалтад хамруулах, мэргэшүүлэх чиглэлээр тусгай хөтөлбөр төлөвлөгөө гарган ажиллав.

Авлигын улмаас нийгмийн тогтвортой болон аюулгүй байдалд учирч буй бэрхшээл, аюул занал нь ардчилсан тогтолцоо, үнэт зүйл, түүнчлэн ёс зүйн үнэт зүйл, шударга ёсыг сулруулж тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулж байгаад сэтгэл зовниж, авлигатай үр дүнтэй тэмцэх арга хэмжээг дэмжиж бэхжүүлэх зорилгоор НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор батлагдсан “Авлигын эсрэг НҮБ-ын Конвенци”-д манай улс 2005 оны 4 дүгээр сарын 29-нд гарын үсэг зуран нэгдэн орсныг 2005 оны 10 дугаар сарын 27-нд УИХ соёрхон баталсан. Үүнтэй холбогдуулан дотоодын хууль тогтоомжийг Конвенцийн үзэл санаатай уялдуулах шаардлага гарч, уг асуудлыг судлан үзэж санал боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан. УИХ-ын даргын 2004 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 125 тоот захирамжаар Авлигын эсрэг хуулийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Авлигатай тэмцэх Үндэсний зөвлөл ажлын хэсэгтэй хамтран уг хуулийн төслийг боловсруулан төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачид, иргэний нийгэм, нийт иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг явуулж олон тооны саналыг хуульд тусган ажилласан.

Авлигын эсрэг хууль батлагдан гарснаар авлигын эсрэг тэмцэх эрх зүйн шинэ орчин бүрдэж, авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлэх, түүнд хяналт тавих ажилд бүх нийтийн хүчийг төвлөрүүлэн ажиллах бололцоо нээгдсэн юм.

Авлигатай тэмцэх Үндэсний зөвлөлийг тодорхой хугацаанд тэргүүлж Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байсны хувьд дараахь саналыг тавьж байна.

Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр боловсруулагдаж байх үеийн нөхцөл байдал өөрчлөгдөж, авлигын талаархи иргэдийн ойлголт дээшилж, авлигатай тэмцэх иргэд, байгууллагуудын хүсэл эрмэлзэл нэмэгдсэн.

Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг боловсруулах ажил хууль тогтоох, шүүх, эрх мэдлийн болон хуулийн байгууллагуудын хүрээнд боловсруулагдаж хэрэгжсэн. Авлигатай тэмцэх ажлыг үр дүнд хүргэхэд төрийн бүх байгууллага, тэр тусмаа гүйцэтгэх засаглалын байгууллагуудын үүрэг оролцоо их ач холбогдолтой байгаа.

Нөгөөтэйгүүр УИХ-аас авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийг соёрхон батлах, Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталж, авлигатай тэмцэх шинэ эрх зүйн орчинг бий болгосон зэргээс үүдэлтэйгээр Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг төрийн бүх шатны байгууллага, иргэний нийгмийн оролцоотойгоор шинэчилж баталж хэрэгжүүлэх нь нэн чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.